



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2013 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Стратегийн төлөвлөгөө батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 16, 13.4.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын Стратегийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Стратегийн удирдлагын газрын захирал (А.Сүхбаатар), Захиргаа, үйлчилгээний газрын захирал (Л.Дулмаа) нарт даалгасуй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

070112
tushaal



2013 - 2018

УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН 2013-2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Ундэсний аудитын газар

2013 он

АГУУЛГА

Ерөнхий аудиторын мэдэгдэл.....	2
Хураангуй.....	3
Алсын хараа, зорилго, зорилтын схемчилсэн хураангуй.....	5
Амжилтын чухал хүчин зүйлс.....	6
Алсын хараа, эрхэмлэх зүйл, үндсэн зарчмууд.....	7
Стратегийн зорилго, зорилт.....	8
Стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн матрикс.....	12
Хавсралтууд	
Хавсралт 1. Үндэсний аудитын газрын бүтцийн схем.....	20
Хавсралт 2. Орчны шинжилгээ.....	21
Хавсралт 3. Товчилсон үг.....	24
Хавсралт 4. Байгууллагын товч түүх	25

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН МЭДЭГДЭЛ**



Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага/ИНТОСАИ/-н Хөгжлийн санаачлага /Аи Ди Аи/ болон Аудитын дээд байгууллагуудын Азийн байгууллага /АСОСАИ/-аас хамтран хэрэгжүүлсэн “Стратегийн төлөвлөгөө”-г боловсруулж, хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд Үндэсний аудитын газрын 2013-2018 онд хэрэгжүүлэх “Стратегийн төлөвлөгөө”-г боловсруулж, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2013 оны ... дугаар тушаалаар баталлаа.

“Стратегийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулж, жил бурийн Үндэсний аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт

нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

“Стратегийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлснээр төрийн аудитын байгууллагуудын хууль эрх зүйн орчинг төгөлдөржиж, бүрэн эрх, хараат бус байдлыг бэхжүүлж, тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж, үйл ажиллагаа болон хийсэн аудитуудын үр нөлөө дээшилж, ажилтнуудын бүтээлч чанар, мэргэжлийн ур чадвар харьцангуйгаар сайжрах юм.

Стратегийн төлөвлөгөөний хэрэгжилт төрийн аудитын байгууллагын нийт ажилтнууд, тэр дундаа аудитор, шинжээчдийн үүрэг хариуцлагаас ихээхэн хамаарах тул Та бүхнийг хүчин чармайлт гарган ажиллана гэдэгт гүнээ итгэж байна.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

А.ЗАНГАД

ХУРААНГҮЙ

Үндэсний аудитын газрын 2013-2018 оны стратегийн төлөвлөгөөг тус байгууллагын гадаад, дотоод нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан боловсруулж, эрхэм зорилго, алсын хараа, эрхэмлэх үндсэн зарчмуудыг тодорхойлов.

БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА:

“Үндэсний аудитын газар нь төрийн бодлого, шийдвэрийн үр дүн, үр нөлөөг сайжруулахад туслан, Монгол улсын хөгжил дэвшилд дэмжлэг үзүүлж, иргэд, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, үнэлэгдэхийг эрмэлзэнэ.”

БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО:

“Улсын Их Хурал хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх болон төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх”

ЭРХЭМЛЭХ ҮНДСЭН ЗАРЧМУУД

Үндэсний аудитын газар болон түүний ажилтнууд **Найдвартай - Шударга - Бодитой** байх зарчмыг эрхэмлэн дээдэлж, Төрийн аудитын төв байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүн хамгийн найдвартай, аливаа нөлөөнд автаагүй, үнэн,

бодитой бөгөөд мэргэжлийн өндөр түвшинд явагдаж байгаа гэдэгт Монголын төр, ард түмэнд итгэл төрүүлж, хүлээн зөвшөөрөгдөж байна.

АМЖИЛТЫН ЧУХАЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Үндэсний аудитын газрын 2013-2018 оны стратегийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд удирдлагын манлайлал, санхүүгийн эх үүсвэр, ажилчдын оролцоо, харилцагчдын дэмжлэг, эрсдэлийн удирдлага зэрэг хүчин зүйлс чухал нөлөөтэй.

2013-2018 оны Стратегийн төлөвлөгөө нь стратегийн 7 зорилго, 21 зорилт дэвшүүлсэн болно. Эдгээрийг хураангуйлан үзүүлбэл:

Стратегийн зорилго-1. УАГ-ын хараат бус байдал ба хууль эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх

Зорилт 1.1 Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх
Зорилт 1.2 Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, эрх зүйн орчныг бэхжүүлэх

Стратегийн зорилго-2. УАГ чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх мэргэжлийн үр чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх

Зорилт 2.1. Мэргэжлийн тасралтгүй сургалтын тогтолцоог хөгжүүлэх

Зорилт 2.2. Мэргэжлийн дадлага туршлагатай, үр дүнтэй ажиллах хүний нөөцийн чадавхийг бий болгох

Стратегийн зорилго-3. УАГ мөрдөгдөж буй аудитын арга зүй ба стандартыг шинэчлэн боловсруулж, олон улсын шилдэг туршлага, арга зүйд нийцүүлэн улам боловсронгуй болгох

Зорилт 3.1. Аудитын арга зүй, олон улсын стандарт, тэргүүний туршлагыг нэвтрүүлэх

Зорилт 3.2. Төрийн аудитын чанарын баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлэх

Зорилт 3.3. Төрийн аудитын орон нутгийн байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах

Стратегийн зорилго-4. Стратегийн оновчтой, үр нөлөөтэй удирдлага, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 4.1. УАГ-ын үйл ажиллагааг өндөр үр дүнд чиглүүлж чадах бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулах

Зорилт 4.2.Хяналт шинжилгээ, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх

Зорилт 4.3 Манлайлал, соёл, ёс зүй, хариуцлагын зөв орчин бүрдүүлж, байнга сайжруулах

Стратегийн зорилго-5. Удирдлага, дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Зорилт 5.1 Ажилтнуудын мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэх орчныг бүрдүүлэх

Зорилт 5.2 Байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх

Зорилт 5.3 Аудитын үр дүнг дэмжих хууль зүйн болон захиргааны зөвлөгөө, туслах үйлчилгээг сайжруулах

Зорилт 5.4 Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангахуйц санхүүгийн нөөц бүрдүүлэх

Стратегийн зорилго- 6.

Харилцагч талуудтай ажиллах тогтолцооны үр нөлөөг сайжруулах

Зорилт 6.1 УИХ-тай харилцах харилцааг сайжруулах

Зорилт 6.2 Судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, экспертуудтэй харилцах харилцааг нэмэгдүүлэх

Зорилт 6.3 Олон нийттэй харилцах харилцааг сайжруулах,

Зорилт 6.4 Гадаад орны түнш байгууллагуудтай олон талт болон хоёр талт хамтын ажиллагааг улам бэхжүүлэх

Стратегийн зорилго-7. Аудитын чанар, үр нөлөөг сайжруулах

Зорилт 7.1 Сайн засаглалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахуйцаар аудитын тайлангийн чанарыг нэмэгдүүлэх

Зорилт 7.2 Олон улсын байгууллага, бусад АДБ-тай хамтарсан аудитын тайлангийн чанарыг нэмэгдүүлэх

Эдгээр Стратегийн зорилго, зорилтууд нь улс орны хөгжил, УИХ, Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны чиглэл, олон нийтийн эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхол, УАГ-ын бүрэн эрх, чиг үүрэгтэй уялдуулан нэн чухал гэсэн асуудлуудыг дэвшүүлсэн юм.

АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО ЗОРИЛТЫН СХЕМЧИЛСЭН ХУРААНГУЙ

Стратегийн зорилго-1. УАГ-ын хараат бус байдал ба хууль эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх
 Зорилт 1.1 Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх
 Зорилт 1.2 Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, эрх зүйн орчныг бэхжүүлэх

Стратегийн зорилго-2. УАГ чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх мэргэжлийн үр чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх

Зорилт 2.1. Мэргэжлийн тасралтгүй сургалтын тогтолцоог хөгжүүлэх

Зорилт 2.2. Мэргэжлийн дадлага туршлагатай, үр дүнтэй ажиллах хүний нөөцийн чадавхийг бий болгох

Стратегийн зорилго-3. УАГ мөрдөгдөж буй аудитын арга зүй ба стандартыг шинэчлэн боловсруулж, олон улсын шилдэг туршлага, арга зүйд нийцүүлэн улам боловсронгуй болгох

Зорилт 3.1. Аудитын арга зүй, олон улсын стандарт, тэргүүний туршлагыг нэвтрүүлэх
 Зорилт 3.2. Төрийн аудитын чанарын баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлэх
 Зорилт 3.3. Төрийн аудитын орон нутгийн байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах

Стратегийн зорилго-4. Стратегийн инноваций, үр нөлөөтэй удирдлага, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 4.1. УАГ-ын үйл ажиллагааг өндөр үр дүнд чиглүүлж чадах бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулах
 Зорилт 4.2.Хяналт шинжилгээ, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх
 Зорилт 4.3. Манлайлал, соёл, ёс зүй, хариуцлагын зөв орчин бүрдүүлж, байнга сайжруулах

БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА:

"Үндэсний аудитын газар нь төрийн бодлого, шийдвэрэйн үр дүн үр нөлөөг сайжруулахад туслан. Монгол улсын хөгжил дээшилд дэмжлэг үзүүлж, иргэд, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдэж, үнэлэгдэхийг эрмэлзэнэ."

БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО:

"Төрийн аудитын үйл ажиллагааг хараат бус, шударга, мэргэжлийн, найдвартай зарчмын дагуу гүйцэтгэж. Улсын Их Хурал хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх болон төсвийн хөрөнгийн арвалан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх"

Стратегийн зорилго-5. Удирдлага, дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Зорилт 5.1 Ажилтнуудын мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэх орчныг бүрдүүлэх

Зорилт 5.2 Байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх

Зорилт 5.3 Аудитын үр дүнг дэмжих хууль зүйн болон захиргааны зөвлөгөө, туслах үйлчилгээг сайжруулах

Зорилт 5.4 Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангахуйц санхүүгийн нөөц бүрдүүлэх

Стратегийн зорилго-6. Харилцаач талуудтай ажиллах тогтолцооны үр нөлөөг сайжруулах

Зорилт 6.1 УИХ-тай харилцах харилцааг сайжруулах

Зорилт 6.2 Судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, экспертуудтэй харилцах харилцааг нэмэгдүүлэх

Зорилт 6.3 Олон нийттэй харилцах харилцааг сайжруулах,

Зорилт 6.4 Гадаад орны түнш байгууллагуудтай олон талт болон хоёр талт хамтын ажиллагааг улам бэхжүүлэх

Стратегийн зорилго-7. Аудитын чанар, үр нөлөөг сайжруулах

Зорилт 7.1 Сайн засаглалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахийцаар аудитын тайлангийн чанарыг нэмэгдүүлэх

Зорилт 7.2 Олон улсын байгууллага, бусад АДБ-тай хамтарсан аудитын тайлангийн чанарыг нэмэгдүүлэх

АМЖИЛТЫН ЧУХАЛ ХҮЧИН ЗҮЙЛС**Удирдлагын манлайлал**

Байгууллагын зорилго, зорилтууд амжилттай хэрэгжихэд удирдлагын манлайлал чухал чиглүүлэгч хүч юм. Идэвхитэй, алсын хараатай, зоригтой, хариуцлагаа ухамсарласан удирдлагын манлайлал нь маш чухал зүйл билээ. Мөн түүнчлэн, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл явцыг оновчтой зохион байгуулахад удирдлагын манлайлал чухал үүрэгтэй.

Санхүүгийн эх үүсвэр

Стратегийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх нэг хүчин зүйл нь санхүүгийн эх үүсвэр, нөөцийг зөв тооцож төлөвлөх явдал юм. Төрийн аудитын тухай хуулийн 8.1-д “Үндэсний аудитын газрын төсвийг түүний саналыг үндэслэн Улсын Их Хурал хэлэлцэн батална. Төсөв нь Үндэсний аудитын газар үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.” гэж заасны дагуу төсвийг хараат бусаар оновчтой төлөвлөж, батлуулснаар стратегийн төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжинэ.

Ажилчдын оролцоо

Стратегийн төлөвлөгөө амжилттай хэрэгжихэд Үндэсний аудитын газрын ажилтнууд жигд хүртээмжтэй оролцох нь ихээхэн үүрэгтэй. Аливаа асуудлыг нээлттэй ил тод, харилцан ойлголцож шийдвэрлэж хэрэгжүүлэх нь стратегийн төлөвлөгөөний зорилго, зорилтууд биелэхэд ихээхэн үр дүнтэй.

Харилцагчдын дэмжлэг

Үндэсний аудитын газрын чадавхийг бэхжүүлэхэд бүх талын харилцагчид ихээхэн чухал үүрэгтэй. Хараат бус байдлаа хадгалангаа харилцагчидтай бүх талын харилцааг зохистой хөгжүүлэх нь стратегийн төлөвлөгөө хэрэгжих нэг үндэс болно.

Эрсдэлийн удирдлага

Стратегийн төлөвлөгөөгөөр дэвшүүлсэн зорилго, зорилтууд хэрэгжихэд нөлөөлөх нэг чухал хүчин зүйл нь эрсдэлийг зөв удирдахад оршино. Зорилго, зорилтууд хэрэгжихэд учирж болох эрсдэлийг тогтмол тодорхойлж, түүнийг бууруулах уян хатан арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь чухал юм.

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛ, ҮНДСЭН ЗАРЧМУУД

БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА:

“Үндэсний ауитын газар нь төрийн бодлого, шийдвэрийн үр дүн, үр нөлөөг сайжруулахад туслан, Монгол улсын хөгжил дэвшилд дэмжлэг үзүүлж, иргэд, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, үнэлэгдэхийг эрмэлзэнэ.”

БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО:

“Улсын Их Хурал хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх болон төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх”

ЭРХЭМЛЭХ ҮНДСЭН ЗАРЧМУУД

Найдвартай - Шударга - Бодитой

ҮАГ болон түүний ажилтнууд нь энэхүү гурван зарчмыг эрхэмлэн дээдэлж, Төрийн аудитын төв байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүн хамгийн найдвартай, аливаа нөлөөнд автаагүй, үнэн, бодитой бөгөөд мэргэжлийн өндөр түвшинд явагдаж байгаа гэдэгт Монголын төр,

ард түмэнд итгэл төрүүлж, хүлээн зөвшөөрөгдөж байна.

Найдвартай байх

ҮАГ-ын үйл ажиллагаа болон гаргаж буй бүтээгдэхүүн болох аудитын тайлан, санал дүгнэлт, зөвлөмж нь мэргэжлийн өндөр чадвартай ажилтнуудын хүчээр өндөр шалгууртай гүйцэтгэлийн удирдлага, нягт хянамгай чанарын хяналтын тогтолцоогоор дамжин боловсруулагдаж, баталгаажсанаар хэрэглэгчдэд хүрч байх тогтолцоо бүрдсэн байх болно.

Шударга байх

ҮАГ нь хараат бусаар үйл ажиллагаа явуулж, хөндлөнгийн төрийн аудитын үүргийг гүйцэтгэх бөгөөд ажилтнууд нь асуудлыг судлах, хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, тайлагнахдаа аливаа нөлөөнд автахгүй шударга байж, ёс зүйг чанд мөрдөж ажиллана

Бодитой байх

ҮАГ олон улсын аудитын стандартын дагуу аудитын ажлын үр дүнг нотлох баримтад түшиглэн боловсруулж, тэнцвэртэй, бодитой мэдээллийг түгээнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ:

2013-2018 оны Стратегийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн Стратегийн зорилго, зорилтууд нь 6 жилийн хугацаанд хэрэгжих боломжтой бөгөөд алсын хараа, эрхэм зорилго ойлгомжтой тодорхой байдлаар томьёолж, түүнд хүрэхийн тулд Стратегийн 7 зорилго, 21 зорилт дэвшүүлсэн болно.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО.

Стратегийн зорилго-1. УАГ-ын хараат бус байдал ба хууль эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх

Стратегийн зорилго-2. УАГ чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх мэргэжлийн ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх

Стратегийн зорилго-3. УАГ мөрдөгдөж буй аудитын арга зүй ба стандартыг шинэчлэн боловсруулж, олон улсын шилдэг туршлага, арга зүйд нийцүүлэн улам боловсронгуй болгох

Стратегийн зорилго-4. Стратегийн оновчтой, үр нөлөөтэй удирдлага, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх

Стратегийн зорилго-5. Удирдлага, дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Стратегийн зорилго-6. Харилцагч талуудтай ажиллах тогтолцооны үр нөлөөг сайжруулах

Стратегийн зорилго-7. Аудитын чанар, үр нөлөөг сайжруулах

СТРАТЕГИ ЗОРИЛТ:

Стратегийн зорилго-1. УАГ-ын хараат бус байдал ба хууль эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх

Зорилт 1.1. ТАБ-ын хараат бус байдлыг бэхжүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Лимагийн тунхаглалд заасан ТАБ-ын хараат бус байдлын нөхцлийг хангасан байх

Зорилт 1.2. ТАБ-ын бүрэн эрх, эрх зүйн орчныг бэхжүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Лимагийн тунхаглалд заасан ТАБ-ын байдлын нөхцлийг хангасан байх

Стратегийн зорилго-2. УАГ чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх мэргэжлийн ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх

Зорилт 2.1. Мэргэжлийн дадлага туршлагатай, үр дүнтэй ажиллах хүний нөөцийн чадавхийг бий болгох

Гүйцэтгэлийн хэмжүүр: Мэргэжлийн тасралтгүй сургалтын тогтолцооны үр дүнд өөрчлөлт гарч, ажилтнуудын чадавх сайжирсан байх

Зорилт 2.2. Мэргэжлийн тасралтгүй сургалтын тогтолцоог хөгжүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Тасралтгүй сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулж, хэрэгжүүлсэн байх

Стратегийн зорилго- 3. УАГ мөрдөгдөж буй аудитын арга зүй ба стандартыг шинэчлэн боловсруулж, олон улсын шилдэг туршлагыг, арга зүйд нийцүүлэн улам боловсронгуй болгох

Зорилт 3.1. Аудитын арга зүй, олон улсын стандарт, тэргүүний туршлагыг шинэчлэн нэвтрүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаандаа аудитын арга зүй, олон улсын стандарт, тэргүүний туршлагыг шинэчлэн нэвтрүүлж, зорилтот түвшинд хүрсэн байна.

Зорилт 3.2. Төрийн аудитын чанарын баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Чанарын баталгаажуулалт хийх тогтолцоог бий болгож тогтмолжуулсан байна.

Зорилт 3.3. Төрийн аудитын орон нутгийн байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах

Гүйцэтгэлийн хэмжүүр: Аймаг, нийслэлийн аудитын газруудад жил бүр арга зүйн сургалтуудыг зохион байгуулж, бүрэн хамруулсан байна.

Стратегийн зорилго- 4.

Стратегийн оновчтой, үр нөлөөтэй удирдлага, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 4.1. УАГ-ын үйл ажиллагааг өндөр үр дүнд чиглүүлж чадах бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулах

Гүйцэтгэлийн хэмжүүр: Салбарын бодлогын баримт бичгүүд, хөтөлбөрүүд шинэчлэн боловсруулагдсан байна.

Зорилт 4.2. Хяналт шинжилгээ, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Дотоод хяналтын тогтолцоог тодорхойлсон УАГ-ын дотоод журмыг шинэчлэгдсэн байна.

Зорилт 4.3. Манлайлал, соёл, ёс зүй, хариуцлагын зөв орчин бүрдүүлж, байнга сайжруулах

Гүйцэтгэлийн хэмжүүр: Удирдлагын зөвлөлийн зүгээс байгууллагыг тохиромжтойгоор удирдан чиглүүлж, төлөвшүүлж, зохих хэв маягийг тодорхойлсон байна.

Стратегийн зорилго- 5.

Стратегийн оновчтой, үр нөлөөтэй удирдлага, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 5.1. Ажилтнуудын мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэх орчныг бүрдүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Сургалтын төвийг барьж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Зорилт 5.2. Байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Байгууллагын өдөр дутмын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж цаасгүй орчин бүрдсэн байна.

Зорилт 5.3. Аудитын үр дүнг дэмжих хууль зүйн болон захиргааны зөвлөгөө, туслах үйлчилгээг сайжруулах

Гүйцэтгэлийн хэмжүүр: Хуулийн зөвлөх мэргэжилтний аудитын үйл ажиллагааны оролцоог тодорхойлсон зааварчилгааг бий болгож хэвшүүлсэн байна.

Зорилт 5.4. Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангахуйц санхүүгийн нөөц бүрдүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Төрийн аудитын байгууллагын төсвийг шууд УИХ-аар батлуулдаг болсон байна.

Стратегийн зорилго- 6. Харилцагч талуудтай ажиллах тогтолцооны үр нөлөөг сайжруулах

Зорилт 6.1. УИХ-тай харилцах харилцааг сайжруулах

Гүйцэтгэлийн хэмжүүр: УИХ, УАБЗ-тэй харилцах мэдээллийн урсгал хэвшсэн, тогтмолжсон байна.

Зорилт 6.2. Судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, экспертуудтэй харилцах харилцааг нэмэгдүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Сургалт судалгааны байгууллагуудтай харилцаж мэдээллийн сантай болсон байх ба энэ чиглэлээр байгууллагын хөрөнгө оруулалтын төсөвт жил бүр тодорхой хөрөнгийг төсөвлөдөг болсон байна

Зорилт 6.3. Олон нийттэй харилцах харилцааг оновчтой болгож, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл тархаалтыг зөв зохион байгуулах

Гүйцэтгэлийн хэмжүүр: ХМХ-ийн тодорхой хэрэгсэлтэй тогтмол харилцаатай болж, байгууллагын үйл ажиллагааг тогтмол хугацаанд нэвтрүүлдэг болно. Олон нийтийн дунд УАГ-ын нэр хүнд өссөн байна.

Стратегийн зорилго- 7. Аудитын чанар, үр нөлөөг сайжруулах

Зорилт 7.1. Сайн засаглалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахуйцаар аудитын тайлангийн чанарыг нэмэгдүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Аудитын үр өгөөж жил 10-15 хувиар нэмэгдсэн байна. Үр өгөөж тооцдог чанарын үзүүлэлтүүд нэмэгдсэн байна.

Зорилт 7.2. Олон улсын байгууллага, бусад АДБ-тай хамтарсан аудитын тайлангийн чанарыг нэмэгдүүлэх

Гүйцэтгэлийн хэмжүүр: Жил бүр 2-3 аудитыг хамтран гүйцэтгэсэн байх, тайлангийн үр дүнг харгалзан давтан аудит хийсэн байна.

Стратегийн төлөвлөгөөг үнэлэх, баяжуулах талаар

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, явцын үнэлгээ дүгнэлт хийж байна. Цаашид орчны шинжилгээ хийж, үүссэн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулж байх болно.

ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗРЫН 2013-2018 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН МАТРИКС

Стратеги зорилго	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэлийн хэмжүүр	Хэрэгжих хугацаа	Нөөц		Хариуцах албан тушаалтан	Эрсдэл	Эрсдэлийн удирдлага
					Эх үүсвэр	Дүн (сая. төгрөг)			
1.УАГ-ын Хараат бус байдал ба хууль эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх	1.1.ТАБ-ын хараат бус байдлыг бэхжүүлэх	1.2.1. Хараат бус байдлын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох	Лимагийн тунхаглалд заасан ТАБ-ын хараат бус байдлын нөхцлийг хангасан байна	2013-2014	Дотоод нөөц	72.0	СУГ-ын болон ЗҮГ-ын захирал	УИХ-аар хуульд өөрчлөлт оруулахад цаг хугацаа алдах, батлагдахгүй байх	Лобби бүлэг байгуулах, ТББ, Иргэний нийгмийн байгууллагуудын мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгийг авах
		Холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах	Лимагийн тунхаглалд заасан ТАБ-ын байдлын нөхцлийг хангасан байна	2013-2014	Дотоод нөөц	36.0	СУГ-ын болон ЗҮГ-ын захирал		
2.УАГ чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх мэргэжлийн ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх	2.1.Мэргэжлийн тасралтгүй сургалтын тогтолцоог хөгжүүлэх	2.1.1. Төрийн аудитын байгууллагын ажилтны мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах	Тасралтгүй сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулсан байна	2013	Дотоод нөөц	18.0	СУГ-ын захирал	Сургалтын хөтөлбөр шаардлагад нийцээгүй байх	Олон улсын туршлага судлах, ажилтнуудын хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлох
		2.1.2. Төрийн аудитын байгууллагын ажилтны мэргэжлийн тасралтгүй сургалтыг	Бүх аудиторуудыг 100 хувь жил бүр тасралтгүй сургалтын хөтөлбөрт туссан тухайн жилийн сургалтаар	2013-2018	Дотоод нөөц	60.0	СУГ-ын болон ЗҮГ-ын захирал	Санхүүгийн нөөц дутагдах, сургалтаар олсон мэдлэгийг ашиглахгүй	

		тогтмолжуулах	хангасан байна					байх	
	2.2 Мэргэжлийн дадлага туршилагатай, үр дүнтэй ажиллах хүний нөөцийн чадавхийг бий болгох	2.2.1. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах	Хүний нөөцийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн гаргасан байна	2013-2018	Дотоод нөөц	15.0	ЗҮГ-ын захирал	Үнэлгээний аргачлал ажилтан бүрт тааламжтай байхгүй байх магадлалтай	Ажлын онцлог тус бүрийг харгалzan үзэх
		2.2.2 Хүний нөөцийн үр нөлөөтэй менежментийн тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх	Ажилтнуудын үр дүнгийн үнэлгээг хийдэг тусгай аргачлал боловсруулан мөрдөж хэвшсэн байна	2013-2018	Дотоод нөөц	28.0	ЗҮГ-ын захирал	Нас, мэргэжлийн онцлогоос хамаарч идэвх харилцан адилгүй байх	Онцлог шинжийг харгалzan үзэж арга хэмжээг төлөвлөх
		2.2.3. Ажилтнуудын цалин, урамшуулал, орон сууц, нийгмийн асуудлыг шийдвэрлэх нийгмийн бодлогын хөтөлбөр боловсруулах	Нийгмийн бодлогын хөтөлбөртэй болсон байна Ажлын орчин нөхцөл норматив хэмжээнд байх, өрөө тасалгаа нэмэгдсэн, уулзалтын өрөөтэй болсон байна	2013-2018	Дотоод нөөц	8.2	ЗҮГ-ын захирал	Хөрөнгө оруулалт шийдэгдэхгүй байх, идэвх санаачилга дутах	Хамтын ажиллагааны олон хувилбарыг эрэлхийлэх
		2.2.4. Ажиллах нөхцлийг сайжруулах	Нийгмийн асуудлыг дэмжсэн хөрөнгө оруулалтын хэмжээг жил бүр нэмэгдүүлж тогтвортой олгодог болсон байна	2013-2018	Дотоод нөөц	8200.0	ЗҮГ-ийн захирал	Хөрөнгө хязгаарлагдм ал байх, идэвх санаачилга дутагдах	Хамтын ажиллагааны олон хувилбарыг эрэлхийлэх
3. УАГ мөрдөгдж буй аудитын арга	3.1.Аудитын арга зүй, олон улсын стандарт,	3.1.1. Аудитын дээд байгууллагуудын олон улсын	Ерөнхий 100 хувь, санхүүгийн болон гүйцэтгэлийн	2013-2016	Дотоод нөөц, Гадаад	3600.0	СҮГ болон ЗҮГ-ын захирлууд	Санхүү болон хүний нөөцийн	Байгууллагын төсөвт жил бүр баталгаажуулж

зүй ба стандартыг шинэчлэн боловсруулж, олон улсын шилдэг туршлага, арга зүйд нийцүүлэн улам боловсронгуй болгох	тэргүүний туршлагыг нэвтрүүлэх	стандартууд /ISSAI/-ыг орчуулж, хэвлүүлэх	аудитын 70 хувь, Нийцлийн аудитын стандартыг 100 хувь орчуулж, хэвлэсэн байна		төслөөс			хязгаарлагдм ал байдал	оруулах Донор байгууллагууда ас төсөл хэлбэрээр санхүүжилт олох
			3.1.2. Нийцлийн болон санхүү, гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагыг боловсронгуй болгох	Нийцлийн аудитын журам, гарын авлагыг шинээр боловсруулж мөрдүүлсэн байх Гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын одоогийн мөрдөж байгаа журам, заавар, гарын авлагыг 100 хувь шинэчлэн боловсруулсан байна	2013-2018	Дотоод нөөц	300.0	СУГ-ын захирал	Цаг хугацаандaa хэрэгжүүлэхгүй байх
			3.1.3. Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартуудыг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх	Гүйцэтгэлийн болон Нийцлийн, санхүүгийн аудитын 50 хувийг /ISSAI/ стандартуудын дагуу гүйцэтгэсэн байна	2014-2018	Дотоод нөөц, Гадаад төслөөс	800.0	Санхүүгийн, Гүйцэтгэлийн болон Нийцлийн аудитын газрын захирлууд	Арга зүйн мэдээг туршлага, дутагдах
3.2. Төрийн аудитын чанарын баталгаажуулал	3.2.1 Чанарын баталгаажуулалтын тогтолцоо болгох	Чанарын баталгаажуулалт хийх тогтолцоог бий болсон байх,	Чанарын баталгаажуулалт хийх тогтолцоог бий болсон байх,	2013-2018	Дотоод нөөц	600.0	Ерөнхий аудиторын орлогч, СУГ	Боловсон хучний нөөц хүрэлцэхгүй байх	Чанарын баталгаажуулалт хийх багийг сонгох бодлого

	тын тогтолцоог төлөвшүүлэх		тогтмолжуулсан байна						боловсруулах, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж байх
	3.3.Төрийн аудитын орон нутгийн байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах	3.3.1. Аймаг, нийслэлийн аудитын газруудыг арга зүйгээр хангах	Аймаг, нийслэлийн аудитын газруудад жил бүр арга зүйн сургалтуудыг зохион байгуулж аудиторуудыг 100 хувь хамруулсан байна	2013-2018	Дотоод нөөц	120.0	СУГ, ЗҮГ	Хөрөнгийн хязгаарлалт, мэргэжлийн хүний нөөц дутагдах	Сургалтын зардлыг өмнөх жилд нь эх үүсвэрийг тодорхойлдог байх, АНАГ-ын төсвийн төлөвлөгөөнд оруулах
4. Стратегийн оновчтой, үр нөлөөтэй удирдлага, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх	4.1 УАГ-ын ўйл ажиллагааг өндөр үр дүнд чиглүүлж чадах бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулах	4.1.1. Төрийн аудитын байгууллагын баримтлах чиглэлийг тодорхойлсон бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулах	Салбарын шинэчлэлийн хөтөлбөрийг боловсруулах Стратегийн төлөвлөгөөг шинэчлэн гаргасан байна. Үүнтэй холбоотой хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөрийг тус тус гаргаж мөрдөж эхэлсэн байна.	2013-2015	Дотоод нөөц	86.0	Удирдлагын зөвлөл	Хэрэгжилтийн хяналт сул байх Гадаад болон дотоод орчны хүчин зүйлээс шалтгаалан бодлогын баримт бичгүүд хэрэгжижгүй байх магадлалтай	Хэрэгжилтийг газар тус бүрээр тодорхой хугацаанд үнэлдэг байх Тухайн нөхцөл байдалд үнэлгээ хийж стратегийн бодлогын баримт бичигт шинэчлэл хийж байх
	4.1.2. Бодлого,	Үйл ажиллагааны	2013-	Дотоод	36.0	СУГ болон	Хэрэгжилтий	Хэрэгжилтийг	

		төлөвлөлтийн баримт бичгүүдийг шинэчлэх, хэрэгжүүлэх	төлөвлөгөө, үнэлгээний тайланг тогтмол хугацаатай гаргадаг болсон байна Хэрэгжилтийг жил бүр үнэлсэн тайлан	2018	нөөц		ЗҮГ-ын захирал	н хяналт сул байх	газар тус бүрээр тодорхой хугацаанд үнэлдэг байх
	4.2.Хяналт шинжилгээ, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх	4.2.1. Дотоод хяналтыг оновчтой зохион байгуулах	Дотоод хяналтын тогтолцоог тодорхойлсон ҮАГ-ын дотоод журмыг шинэчилсэн байна	2013	Дотоод нөөц	18.0	Ерөнхий аудиторын орлогч, ЗҮГ-ын захирал	Дотоод хяналтыг бүрэн тодорхойлоо гүйгээс хяналт сулрах	Дотоод хяналтын схемийг нарийвчлан гаргасны дүнд боловсруулах
	4.3 Манлайлал, соёл, ёс зүй, хариуцлагын зөв орчин бүрдүүлж, байнга сайжруулах	Байгууллагыг тохиромжтойгоор удирдан чиглүүлэх хэв маягийг төлөвшүүлэх, ёс зүйн шаардлага нийцэж буй эсэх баталгаагаар хангах бодлого горимыг шинэчлэн боловсруулах	Ёс зүйн хороо байгуулагдсан байх, ёс зүйн дүрэмийг шинэчилсэн байна	2013-2018	Дотоод нөөц	8.0	Удирдлагын зөвлөл, Ёс зүйн хороо	Ёс зүйн дүрэм зөрчсөнийг мэдэхгүй байх	Аудит хийсэн байгууллагуудаас ёс зүйгээ баримталсан эсэх талаар ЗҮГ-ээс санал авах, зөвлөлөөр хэлэлцүүлдэг байх
5. Удирдлага, дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	5.1 Ажилтнуудын мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэх орчныг бүрдүүлэх	5.1.1 Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын сургалтын төв байгуулах	Сургалтын төвийг барьж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна	2013-2018	Дотоод нөөц	9200.0	ЗҮГ	Санхүүжилт батлагдахгүй байх, Санхүүжилт хугацаандаа орж ирэхгүй байх	Жил бүрийн улсын төсвийн хөрөнгө оруулалт, үндсэн чиглэлд зайлшгүй тусгуулах, Лобби бүлэг ажиллуулах
	5.2 Байгууллагын	5.2.1 Мэдээллийн технологийн	Байгууллагын өдөр дутмын үйл	2013-2015	Дотоод нөөц,	700.0	Ерөнхий аудиторын	Ажилтнуудад бүрэн	Ач холбогдлыг ажилтнуудад

үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх	ашиглалтын бодлого, чиглэлийг тодорхойлох	ажиллагаа цахим хэлбэрт шилжиж цаасгүй орчин бүрдсэн байна.		гадаад төслөөс		орлогч, газрын захирлууд	оилгуулаагүй гээс ашиглахгүй байх	сайн ойлгуулах, сургалт явуулах, дэс дараатай хэрэгжүүлэх
	5.2.2 Аудитад судалгааны болон мэдээлэл боловсруулалтын программ хангамжийг нэвтрүүлэх	Санхүүгийн аудит 100 хувь, Гүйцэтгэл, нийцлийн аудит 60 хувь цахим сүлжээнд нэвтэрсэн байх Аудитад шаардлагатай программ хангамжийг нэвтрүүлсэн байна	2013- 2018	Дотоод нөөц	1300.0	Аудитын газрын захирлууд	Санхүүгийн болон хүний нөөц дутагдах	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах, програм хангамжийн мэргэжилтэнг бэлтгэх
	5.2.3 Дотоод мэдээлэл, мэдээллийн технологийн дэд бүтэц, орчин нөхцлийг сайжруулах	Байгууллагын үйл ажиллагаа бүрэн цахим дотоод сүлжээгээр явагддаг болсон байна	2013- 2018	Дотоод нөөц	200.0	ЗҮГ-ын захирал	Ажилтнуудад бүрэн ойлгуулаагүй гээс ашиглахгүй байх	Ач холбогдлыг ажилтнуудад сайн танилцуулах
	5.3 Аудитын үр дүнг дэмжих хууль зүйн болон захиргааны зөвлөгөө, туслах үйлчилгээг сайжруулах	Аудитын багийн бүрэлдэхүүн, хууль зүйн болон захиргааны ажилтнуудын оролцоог тодорхой болгох	Хуулийн зөвлөх мэргэжилтний аудитын үйл ажиллагааны оролцоог тодорхойлсон зааварчилгааг бий болгож хэвшүүлсэн байна	2013- 2018	Дотоод нөөц	80.0	ЗҮГ-ын захирал	-
	3.1.3. Чанарын удирдлагын тогтолцоо /ISO 9001/-г нэвтрүүлэх	ISO-т үйл ажиллагаандaa бүрэн нэвтрүүлсэн байна	2013- 2018	Дотоод нөөц	78.0	ЗҮГ-ын захирал	-	-

Үндэсний аудитын газрын 2013-2018 оны стратегийн төлөвлөгөө


2012

	5.4 Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангахуйц санхүүгийн нөөц бүрдүүлэх	5.4.1 Төрийн аудитын байгууллагын санхүүгийн хараат бус байдлыг хангахуйц нөөцийг төлөвлөж, батлуулах арга хэмжээ авах	Төрийн аудитын байгууллагын төсвийг шууд УИХ-аар батлуулдаг болсон байна	2013-2018	Дотоод нөөц, Гадаад төслөөс	90.0	ЗҮГ-ын захирал	Хөрөнгө оруулалт шийдвэрлэхгүй байх	Хөрөнгийн эх үүсвэрийн Сястай, төлөвлөгөөнд суулгах асуудлыг ЭЗХЯнд асуудал оруулж шийдвэрлүүлэх
6. Харилцагч талуудтай ажиллах тогтолцооны үр нөлөөг сайжруулах	6.1 УИХ-тай харилцах харилцааг сайжруулах	6.1.1 УИХ-тай харилцах журмыг оновчтой болгох	УИХ, ҮАБЗ-тэй харилцах мэдээллийн урстгал хэвшсэн, тогтмолжсон байна	2013	Дотоод нөөц, Гадаад төслөөс	108.0	ЗҮГ-ын захирал	-	-
	6.2 Судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, экспертуудтэй харилцах харилцааг нэмэгдүүлэх	6.2.1 Аудитад судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, экспертуудийг тогтмол ашигладаг болох	Сургалт судалгааны байгууллагуудтай харилцаж мэдээллийн сантай болсон байх ба энэ чиглэлээр байгууллагын хөрөнгө оруулалтын төсөвт жил бүр тодорхой хөрөнгө тусгасан байна.	2013-2018	Дотоод нөөц	450.0	ЗҮГ-ын захирал	Төсөвлөсөн хөрөнгө хүрэлцэхгүй байх	Төлөвлөгөөт бус аудитын тоог хязгаарлах
	6.3 Олон нийттэй харилцах харилцааг сайжруулах,	6.3.1 Олон нийттэй харилцах харилцааг оновчтой болгож, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл тархаалтыг зөв зохион байгуулах	XMX-ийн тодорхой хэрэгсэлтэй тогтмол харилцаатай болж, байгууллагын үйл ажиллагааг	2013-2018	Дотоод нөөц	72.0	ЗҮГ-ын захирал	Хөрөнгө хязгаарлагдмал, Мэдээлэл тархаалтад хэт олон сувгаар тархах,	Хөрөнгө оруулалтын төсөвт заавал тусгаж хэвших, Гол сувгийг тодорхойлж, хугацаа, хөрөнгийг

			тогтмол хугацаанд нэвтрүүлдэг болно. Олон нийтийн дунд ЯАГ-ын нэр хүнд өссөн байна.					хөрөнгө зарцуулалт ихсэх	тогтмолжуулах
	6.4 Гадаад орны түнш байгууллагуудтай олон талт болон хоёр талт хамтын ажиллагааг улам бэхжүүлэх	6.4.1 Гадаад орны түнш байгууллагуудтай олон талт болон хоёр талт хамтын ажиллагаа хөгжүүлэх бодлогыг тодорхойлох	Гадаад түнш байгууллагын тоо 10 хувиар өссөн байна. Өөрчлөлтийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар жил бүрийн үйл ажиллагааны тайланд тусгасан байна	2013-2018	Дотоод нөөц	900.0	ЗУГ-ын захирал	Гадаад түншийн харилцаа тогтвортгүй байх	Хамтын ажиллагааг идэвхтэй байлгах арга хэмжээ зохион байгуулах
7. Аудитын чанар, үр нөлөөг сайжруулах	7.1 Сайн засаглалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахуйцаар аудитын тайлангийн чанарыг нэмэгдүүлэх	7.1.1 Аудитын үр өгөөжийг тогтмол дээшлүүлэх	Аудитын үр өгөөж жил 10-15 хувиар нэмэгдсэн байх Үр өгөөж тооцдог чанарын үзүүлэлтүүд нэмэгдсэн байна	2013-2018	Дотоод нөөц	0	Санхүүгийн, Гүйцэтгэлийн болон Нийцлийн аудитын газрын захирлууд	Үйлчлүүлэгч байгууллага үр өгөөжийн талаар мэдэгдэхүүнгүй байх	Харилцагч байгууллагуудтай үр өгөөжийг тооцсоны ач холбогдлыг сурталчлах
	7.2 Олон улсын байгууллага, бусад АДБ-тай хамтарсан аудитын тайлангийн чанарыг нэмэгдүүлэх	7.2.1 Хамтарсан аудит, арга хэмжээг үр нөлөөтэй зохион байгуулах	Жил бүр 2-3 аудитыг хамтран гүйцэтгэсэн байх, тайлангийн үр дүнг харгалзан давтан аудит хийсэн байна	2013-2018	Дотоод нөөц	135.0	СУГ-ын захирал	Аудитыг хэрэгжүүлэх болон тайлагнах арга зүй зөрүүтэй байх	Урьдчилан уулзалтаар нөхцөл байдлыг зөв тодорхойлох

ХАВСРАЛТ 1. ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН БҮТЦИЙН СХЕМ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН БҮТЦИЙН СХЕМ



ХАВСРАЛТ 2. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

SWOT шинжилгээг Үндэсний аудитын газрын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, цаашид стратегийн төлөвлөгөөнд тусган анхаарч ажиллах зорилгоор хийсэн. Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг **Санал асуулга, ярилцлага, онилсон бүлгийн ярилцлага, баримт бичгийн судалгаа** хийх зэрэг аргуудыг ашигласан болно. Бүх санал асуулга, ярилцлага, судалгаагаар Үндэсний аудитын газрын буюу төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны **давуу талын** талаар 168, **сул талын** талаар 278, **боломж, бололцооны** талаар 150, **аюул заналын** талаар 120, бүгд 716 мэдээлэл цуглувлагдсныг нэг бүрчлэн ангилж ялган, нэгтгэн дүгнэлээ.

Хууль эрх зүйн орчин ба хараат бус байдлын талаар:

ҮАГ нь Төрийн аудитын тухай хууль тогтоомжийн хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа бөгөөд Төсвийн тухай хууль, Засгийн газрын болон яам, агентлагын эрх зүйн байдлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай

хууль зэрэг хууль тогтоомжийн орчинд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Төрийн аудитын тогтолцоо, байгууллагын чиг үүргийн талаар тодорхой тусгаагүй бөгөөд энэ талаар эрх бүхий байгууллагын анхаарлыг хандуулахын зэрэгцээ Төрийн аудитын тухай хуулийн орчин, хэрэгжилтийг сайн судалж, дүгнэлт хийж цаашид боловсронгуй болгох хэрэгцээ үүссэн гэж үзэж болохоор байна.

Мөн өөрийн бүтэц, зохион байгуулалтаа бие даан хийж аудитын сэдэв, хамрах хүрээгээ сонгон үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд түүнийг дэмжсэн хангалттай санхүүгийн нөөц бүрдүүлэх хараат бус байдал хангагдаж чадаагүй байна.

Удирдлагын манлайлал ба дотоод засаглалын талаар:

Монгол Улсын Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогчийг УИХ-с томилж, МУЕА-нь газрын захирал, ажилтнуудаа сонгон томилж байгаа бөгөөд газрын захирлууд нь ажилтнуудтай гэрээ байгуулан, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэн ажиллаж байна.

Удирдлагын зүгээс манлайллыг хангах, сайжруулах талаар төдийлөн анхаарахгүй байгаа бөгөөд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь ажилтнуудын тэдний хүсэл, сонирхолд нийцэхгүй байна.

Мөн байгууллагын хүрсэн түвшиндээ үнэлгээ, дүгнэлт өгч, өөрчлөлт, шинэчлэлтийг нэвтрүүлэх, байнгын сайжруулалт хийх ажил иж бүрэн, жигд бус бөгөөд захирал, менежер, ахлах ажилтнуудын ур чадвар мэргэжлийн өндөр түвшинд ажиллах шаардлагад төдийлөн хүрээгүй байна.

Хүний нөөцийн бодлого, зохицуулалтын талаар:

Байгууллагын хүний нөөц бүрдүүлэх сонгон шалгаруулалт хийх, сургаж хөгжүүлэх, үр дүнгийн гэрээ байгуулж, үнэлэх, урамшуулах асуудлыг өөрсдийн баталсан журмын дагуу хэрэгжүүлж байна.

Мөн мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, үүрэгт ажлаа үр нөлөөтэй гүйцэтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлж байна.

Ажилтнуудын үр дүнгийн үнэлгээг оновчтой хийхгүй байгаа нь тэднийг идэвхжүүлэх, ажлын үр

бүтээлийг дээшлүүлэх хөшүүрэг болж чадахгүй байна.

Шинээр авах ажилтанд тавигдах шаардлагыг шинэчилж, өндөр ёс суртахуун, мэргэжлийн мэдлэг, мэргэшил, ур чадвартай ажилтнуудаар боловсон хүчний нөөцөө бүрдүүлэх нь тулгамдсан асуудал болж байна.

Удирдлагын хяналтын талаар:

Дотоод хяналт, дотоод аудит хууль журмын дагуу хийгдэж байгаа бөгөөд түүний үр нөлөөг ач холбогдол өгч, анхаарч үзэхгүй байгаагаас аудитын ажлын мөрөөр зохиогдох ажил хангалтгүй байна.

Гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын журам, санхүүгийн аудитын гарын авлага, стандартын хэрэгжилтийн хяналтыг шат шатандаа сайжруулах шаардлагатай байна.

Олон нийттэй харилцах талаар:

Байгууллагын үйл ажиллагааг WEB хуудсаар дамжуулан түгээж байгаа бөгөөд аудитын тайланг харилцагчдад хэвлэн хүргэж, хэвлэлд зарим асуудлаар мэдээлэл тавьж иргэдийг мэдээллээр хангаж байна.

Олон улсын байгууллагууд, гадаад орнуудтай харилцаа, хамтын

ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж байгаа бөгөөд аудитын шилдэг арга зүй, хандлагаас судалж, суралцан, үйл ажиллагаандаа нэвтрүүлж ирсэн.

Мэдээллийн ил тод, нээлттэй хүртээмжтэй байдлыг бодлого, журмын хүрээнд зохион байгуулж явуулах шаардлага тулгарч байна. Үндэсний аудитын газраас УИХ-тай болон бусад харилцагч байгууллагуудтай харилцах асуудлыг судалж тусгай журам боловсруулан шийдвэрлэх хэрэгтэй байна.

Аудитын үйл явцын талаар:

Гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитыг төлөвлөгөөний дагуу болон УИХ-ын захиалгын дагуу жил бүр гүйцэтгэж, улсын төсвийн төсөлд жил санал, дүгнэлт гарган УИХ-аар хэлэлцүүлж байна.

Аудитыг аудитын арга зүй, олон улсын стандартын хүрээнд явуулж байна. Гэвч аудитын ажилд судалгааны аргууд, мэдээллийн технологийн ашиглалтын асуудал шаардлагын түвшинд хүрээгүй байна.

Аудитын чанарын баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн гарын авлага боловсруулж түүнийг мөрдүүлж

байгаа боловч төлөвшиж чадаагүй байна.

Аудитын үр өгөөжийг жил тутам тооцож, судалгаа, дүгнэлт хийн ажиллаж байгаа бөгөөд үр өгөөж жил бүр тогтмол өсч байгаа болно. Харин санхүүгийн бус үр өгөөжийн ач холбогдол, тооцоолол дутмаг байгаа юм.

Аудитын үр дүнгийн талаар:

Аудитын тайлангийн дагуу холбогдох байгууллагуудад өгч байгаа зөвлөмжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл авч байгаа бөгөөд харин зөвлөмжийн дагуу зохиогдсон ажил, түүний үр нөлөөг үнэлж, дүгнэхгүй байна.

Мөн гүйцэтгэсэн аудитын чанар, аудитаас өгөх баталгаа, аудитын илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжийн үндэс суурь болсон аудитын ажлын баримтын бүрдүүлэлт, хяналт, тэдгээрийн баримтжуулалтын байдалд хангалттай дэвшил гарч чадахгүй байна.

ХАВСРАЛТ З. ТОВЧИЛСОН ҮГ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИНТОСАИ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
Аи Ди Аи	ИНТОСАИ-н Хөгжлийн санаачлага
АСОСАИ	Аудитын дээд байгууллагуудын азийн байгууллага
ИССАИ (ISSAI)	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЕАО	Ерөнхий аудиторын орлогч
СУГ	Стратегийн удирдлагын газар
ЗҮГ	Захиргаа, үйлчилгээний газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
АНАГ	Аймаг, нийслэлийн аудитын газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
АДБ	Аудитын дээд байгууллага

ХАВСРАЛТ 4. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТҮҮХ

Монгол Улсад Төрийн хяналт шалгалтын байгууллага 1922 оны 6 сарын 23-ны өдөр Хянан байцаах хэлтэс нэтрэйгээр анх байгуулагдсан түүхтэй. Өнгөрсөн 90 жилийн хугацаанд төрийн хяналт шалгалтын байгууллага олон удаа өөрчлөн зохион байгуулагдаж байснаас гадна нэг бус удаа татан буугдаж, дахин шинээр байгуулагдаж байсан. Төрийн хяналт шалгалтын байгууллага бүрийн бүтэц, чиг үүрэг ч янз бүр байжээ.

Монгол Улс социалист чиг баримжаагаар хөгжиж байгаад 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэн юм. Монгол Улсын Парламент 1995 онд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, 2003 онд Төрийн аудитын тухай хууль баталснаар өнөөдрийн аудитын дээд байгууллагын тогтолцоо бүрдэн үйл ажиллагаагаа явуулж байгаа болно.

Төрийн аудитын тухай хуулиар төрийн аудитын үндсэн зарчим, төрийн аудитын хэлбэрүүд, төрийн аудитын байгууллагын тогтолцоо, Үндэсний аудитын газар, аймаг, нийслэлийн аудитын газрын тухай болон

тэдгээрийн төсвийн тухай, Ерөнхий аудиторын бүрэн эрх, төрийн аудитын байгууллагын боловсон хүчин, аудит хийх бүрэн эрх, аудитын төлөвлөлт баталгаажуулжээ. Төрийн аудитын тухай хууль долоон бүлэг, 29 заалттай бөгөөд Монголын төрийн аудитын байгууллагын талаарх ойлголтыг тодорхой болгохын тулд хуулийн зарим зүйл, заалтаас тодруулбал: 5.1-д “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудит хийнэ.” 6.1-д “Төрийн аудитын байгууллагын тогтолцоо нь төрийн аудитын төв, орон нутгийн байгууллагаас бүрдэнэ.

Төрийн аудитын төв байгууллага нь Үндэсний аудитын газар, орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлийн аудитын газар байна.” 7.2-д “Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Ерөнхий аудиторын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно.” 8.1-д “Үндэсний аудитын газрын төсвийг түүний саналыг үндэслэн Улсын Их Хурал хэлэлцэн батлана.

Төсөв нь Үндэсний аудитын газар үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.” 15.1.1-д “Үндэсний аудитын газар Улсын Их Хурлаас бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийнэ.” 15.1.9-д “Үндэсний аудитын газар улсын төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээглүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж Улсын Их Хуралд оруулна.” 17.1-д “Үндэсний аудитын газар аудитын ажлын болон тайлагнах стандарт баталж Төрийн аудитын байгууллагын болон дотоод хяналтын ажилтан, төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс аудит хийж буй мэргэжлийн аудитороор мөрдүүлнэ.

Энэ стандарт нь аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт, тухайлбал, хяналт шалгалтын дээд байгууллагуудын олон улсын байгууллага, Нягтлан бодогчдын олон улсын холбооны стандартад нийцсэн байна.” 20.2-д “Монгол Улсын Ерөнхий аудитор улс орны эрх ашгийн төлөө гэж үзсэн аливаа асуудлаар санал, зөвлөмж бэлтгэж Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, холбогдох бусад

байгууллага, албан тушаалтанд танилцуулж болно.” 21.1-д “... байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.” гэжээ.

Дээрх заалтууд нь Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, хараат бус байдлыг тодорхойлж байгаа хэрэг мөн.

